МЭДЭЭ · 2022 оны 12-р сарын 16

# “ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО, ХУУЛЬ ЗҮЙН ТОГТОЛЦОО” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЖ БАЙНА






Тээврийн прокурорын газраас Тээврийн цагдаагийн албатай хамтран “Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллагын үүрэг оролцоо, хууль зүйн тогтолцоо” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг өнөөдөр /2022.12.16/ зохион байгуулж байна.

Уулзалтад Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын бүртгэлт хяналтын төв, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн Автозамын хөгжлийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албад, Авто сургуулийн холбоодын төлөөлөл оролцон мэдээлэл хийж, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын хоорондох хамтын ажиллагааг хангах, шаардлагатай асуудлаар санал солилцох ажээ.




Тээврийн прокурорын газар, Тээврийн цагдаагийн албанаас дээрх байгууллагын төлөөллүүдээс хийсэн мэдээлэл, танилцуулга, оролцогчдоос гаргасан санал, шүүмжлэл, зам тээврийн ослын нөхцөл байдалд үндэслэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагаа, түүний үр нөлөөг дээшлүүлэх талаар холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэхээр төлөвлөж байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=WvSJwQh-Of0






Прокурор нь эрүүгийн болон зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавьж, эрүүгийн болон зөрчлийн хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад оролцох, прокурорын байгууллага үйл ажиллагаандаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байна.
Прокурорын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь хэсэгт "Прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулиа, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг бариманлаж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангана" гэж
Прокурорын тухай хуулийн 11 дүгээр зүйлд "Зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт", 14 дүгээр зүйлд "Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт" гэж прокурорын хяналтыт хэрэгжүүлэх прокурорын бүрэн эрх, прокурорын хяналтын арга хэлбэрийг
хуульчилжээ.
THE PROSECUTOR GENERAL'S OFFICE OF MONGOLIA
Panasonic
УЛААНБААТАР






DELL






Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2069